

**ХӨСӨГ ТРЕЙД ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 2019/01

Улаанбаатар хот

[Санхүүгийн болон үйл ажиллагааны]
тайлан батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1.9 дэхь заалт, “ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн 2019 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2018 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

/Л.МЯГМАРЖАВ/



ХӨСӨГ ТРЕЙД ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 209/02

Улаанбаатар хот

“Компанийн ТУЗ-ийн гишүүдийг”

сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, дахь заалт болон “ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн 2019 оны 05 дугаар сарын 18-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Л.Мягмаржав
2. Д.Нямбаяр
3. Д.Бямбажал
4. Л.Цэгмид
5. Б.Анхбаяр
6. Ч.Батмөнх

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Ц.Оюунтуяа
2. С.Мөнхгэрэл
3. Б.Төрсайхан

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

/Л.МЯГМАРЖАВ/



ХӨСӨГ ТРЕЙД ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 2019/03

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн цалин урамшуулалыг

батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, дахь заалт болон **“ХӨСӨГ ТРЕЙД”** ХК-ийн 2019 оны 05 дугаар сарын 18-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшуулалын төсвийг хавсралт № 01 тоотой баталсугай.

2. Батлагдсан төсвийг дагуу цалин урамшуулалыг бодож олгохыг нягтлан бодогчид даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

/Л.МЯГМАРЖАВ/

